



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/546

Улаанбаатар хот

Угаарын хийн хордлогоос урьдчилан  
сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.7, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

1.1.Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд жил бүрийн хавар, намрын улиралд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт;

1.2.Сайжруулсан түлшний нөөцлөлт, тээвэрлэлтийн үеийн хадгалалтын горим, чанар, стандартыг хангаж, стандартын шаардлага хангаагүй зуухтай айл өрхийн судалгааг гарган, зуухны битүүмжийг шалгах, зөв галлагааны зөвлөмж болон угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн ажиллагааны зааварчилгаа өгөх, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг "Таван толгой түлш" ХХК (М.Ганбаатар)-д;

1.3.Угаарын хийн хордлогын дуудлага мэдээллийг бүртгэлжүүлж, иргэдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, анхны тусламж үйлчилгээ үзүүлэх талаар зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж)-т;

1.4.Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой зөвлөмж мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн сургалт, судалгаа олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т;

1.5.Зах, худалдааны төвүүдэд худалдаалагдаж байгаа ахуйн хэрэглээний зуухны стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Батшагай)-т;

1.6.Гэр хорооллын айл өрхийн ахуйн хэрэглээний зуухны MNS5216:2016 стандартыг иргэдэд сурталчлах, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, сайжруулсан түлшний чанар, хангамжийн асуудалд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд)-т;

111720001763

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлыг бууруулах асуудал хариуцсан орлогч (П.Баттөр)-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Д.СУМЪЯАБАЗАР